



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Татан буугдсан хуулийн этгээдийн
хөрөнгийг шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 188 дугаар тогтоолын 5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” төрийн өмчит үйлдвэрийн газар татан буугдаж байгаатай холбогдуулан хаалтын тайланд тусгагдсан нийт 1,108,849,243.29 (нэг тэрбум нэг зуун найман сая найман зуун дөчин есөн мянга хоёр зуун дөчин гурван төгрөг хорин есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн болон эргэлтийн хөрөнгийг “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” улсын төсөвт үйлдвэрийн газарт шилжүүлсүгэй.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ